



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2018 ОНЫ ГУРАВДУГААР САР



Улаанбаатар 2018 он

Өмнөх үг

Гэмт явдал нь өөрөө нийгмийн хамгийн аюултай, сөрөг үзэгдэл бөгөөд байгаль, нийгмийн эерэг, сөрөг үзэгдэл болон хүний үйл ажиллагаанаас хамааралтайгаар өөрчлөгдөж байдаг зүй тогтолтой. Тэгвэл гэмт хэрэг гэх үзэгдлийг дангаар нь судлах явдал ямар ч үр дүнгүй болох нь ойлгомжтой.

Гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг судлахад зөвхөн хууль, эрх зүйн ба социологийн мэдлэг шаардаад зогсохгүй математик, статистик, улс төр, эдийн засаг, нийгмийн сэтгэл зүй, техник технологи зэрэг байгаль, нийгмийн шинжлэх ухааны мэдлэгийг тодорхой хэмжээнд эзэмшсэн байхыг шаардаж байна.

Ер нь гэмт хэрэг нь дан ганц хулгай, дээрэм, хүний амь насыг хөнөөх, хүчиндэх хэргүүдээр хязгаарлагдаггүй, мөн санхүүгийн хямрал, ан амьтан, ургамал устах, ус агаар бохирдох, хүн амын өвчлөлт, улс төрийн зөрчилдөөн зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг багтаадаг ба нийгмийн янз бүрийн харилцаануудыг ямар нэг байдлаар зөрчих хэлбэрээр илэрдэг маш өргөн агуулгатай юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөж гэмт хэргийн гаралт, түүний хор уршгийг бууруулах, саармагжуулахын тулд шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан сэргийлэх ажлыг өргөн цар хүрээтэй зохион байгуулах явдал чухал юм.

Гэмт явдал, түүний шалтгаан нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүн, түүний төлөвшин тогтох таатай болон тааламжгүй нөхцөл байдлууд, тэдгээртэй тэмцэх арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллүүдийг цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэж дүн шинжилгээ хийх тодорхой арга хэрэгслүүдийг криминологийн судалгааны арга зүй гэж нэрлэдэг.

Гэмт хэргийн статистикийн судлах зүйлд гэмт хэргийн гаралт, тархалт, бүтэц, динамик, түүний шалтгаан нөхцөл, гэмт хэрэгтэн бие хүн, гэмт халдлагад өртсөн хохирогч иргэн, байгууллага, түүнээс учирсан нийгэм, эрх зүйн хор хохирол, үр дагавар, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааны чиглэл өгөх, ажлын үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг ойлголт хамаардаг.

Бүртгэгдсэн гэмт хэрэг


2018 оны эхний 3 сард нийслэл хотод нийт 7975 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 3622 (83.2%) хэргээр нэмэгдсэн байна. Сонгинохайрхан дүүрэгт оны эхний 3 сард 1240 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 575 (86.5 %) хэргээр өссөн байна. Тайлант хугацаанд нийслэлд гарсан хэргийн 18.2 хувь нь Баянгол дүүрэгт, 29.4 хувь нь Баянзүрх дүүрэгт, 15.9 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 9.9 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 8.1 хувь нь Хан-уул дүүрэгт, 1.0 хувь нь Багануур дүүрэгт, 1.7 хувь нь Налайх дүүрэгт гарсан байна.

Хүснэгт 1. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, дүүргээр

Хэрэг бүртгэгдсэн байгууллага	Бүх хэрэг		Өсөлт, бууралт %	Гэмт хэргийн ангилал				Согтуугаар үйлдэгдсэн		Хүүхэд оролцсон		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	
	2017	2018		хөнгөн		хүнд		2017	2018	2017	2018	2017	2018
				2017	2018	2017	2018						
Нийслэл	4353	7975	183.2	2284	6008	224	1967	703	200	134	68	219	184
Баянгол	746	1448	194.1	434	1252	33	196	147	23	21	12	27	19
Баянзүрх	993	2349	2.4 дах	540	1766	47	583	187	44	27	16	65	43
Сүхбаатар	742	1269	171.0	399	1017	35	252	73	13	17	9	23	25
Сонгинохайрхан	665	1240	186.5	309	770	51	470	107	34	26	13	41	27
Хан-уул	408	650	159.3	229	487	16	163	44	13	16	1	34	35
Чингэлтэй	644	787	122.2	296	536	32	251	96	31	22	8	22	20
Багануур	55	84	152.7	35	65	4	19	21	36	1	5	7	7
Багахангай	6	14	2.3 дах	1	9		5	2	2		1		1
Налайх	94	134	142.6	41	106	6	28	26	4	4	3		7

Нийслэлд оны эхний 3 сард гарсан хэргийн 6008 (75.3%) нь хөнгөн, 1967 (24.7%) нь хүнд хэрэг байна. Дүүргийн хэмжээнд нийт гарсан хэргийн 770 (62.1%) нь хөнгөн, 470 (37.9%) нь хүнд хэрэг байна. Нийслэлд оны эхний 3 гарсан нийт хүнд хэргийн 23.9 хувь нь Сонгинохайрхан дүүргийнх байна.

Зураг 1. Гэмт хэргийн тоо, хувиар, дүүргээр




2018 оны эхний 3 сард нийслэлд хүний амьд явах эрхийн эсрэг хэрэг 191(2.4%) гарснаас 22 (11.5 %) нь хүнийг алах гэмт хэрэг байна. Сонгинохайрхан дүүрэгт хүнийг алах гэмт хэрэг 7 (3.7%) гарсан байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг нийслэлд 1725 (21.6%) гарснаас 258(14.9%) нь Сонгинохайрхан дүүрэгт гарсан байна.

Хүснэгт 2. Гэмт хэргийн тоо, хэргийн ангиллаар, дүүргээр

Хэрэг бүртгэгдсэн байгууллага	Хүний амьд явах эрхийн эсрэг		хүнийг алах		Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг		хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах		хүний эрүүл мэндэд хүндэтэр хохирол санаатай учруулах		хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол хохирол учруулах		гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Нийслэл	127	191	28	22	1236	1725	72	34	96	67	1056	1536		68
Баянгол	14	29	4	2	257	322	10	8	25	14	219	292		5
Баянзүрх	39	64	9	5	299	464	17	8	20	22	259	416		14
Сүхбаатар	16	24	4	2	171	241	11	3	14	11	146	215		11
Сонгинохайрхан	19	27	7	7	197	258	15	6	21	4	160	237		8
Хан-уул	13	19	2	2	111	185	3	3	4	3	104	162		14
Чингэлтэй	12	19	1	4	140	170	12	2	7	7	117	152		8
Багануур	3	2			26	39	4	3	1	3	20	33		
Багахангай	1	2			2	7			1		1	5		2
Налайх	10	5	1		33	39		1	3	3	30	24		6

Тайлант оны эхний 3 сард Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 27 (2.2%) нь хүний амь явах эрхийн эсрэг, 258 (19.0%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 22 (1.8%) нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, өмчлөх эрхийн эсрэг 870 (70.2%), 1 (0.1%) хүүхдийн эсрэг, 30 (2.4%) хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг хэрэг байна.

Зураг 2. Сонгинохайрхан дүүргийн гэмт хэргийн тоо, хэргийн ангилалаар



2018 оны эхний 3 сард нийслэл хотод хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг хэрэг 86(1.2%) гарнаас 72 (83.7%) хүчиндэх хэрэг байна. Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт 21 (29.2%) хүчингийн хэрэг гарсан байна.


Хүснэгт 2-ийн үргэлжлэл

Хэрэг бүртгэгдсэн байгууллага	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг		хүчиндэх		Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг		Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг		Эрүүл мэндийн эсрэг	Хүүхдийн эсрэг
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2018	2018
	Нийслэл	65	86	32	72	7	29	12	3	9
Баянгол	13	16	5	14	1	4			2	3
Баянзүрх	12	19	6	16		9	2	1	2	1
Сүхбаатар	6	10	5	9	5	3		2	4	
Сонгинохайрхан	13	22	5	21		4				1
Хан-уул	7	5	5	4	1	7	2			
Чингэлтэй	10	11	4	5		2				
Багануур	2	1		1						
Багахангай		1		1						
Налайх		1		1			8		1	1

2018 оны эхний 3 сард гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг нийслэл хотод 83 (21.1%) гарснаас 15 (18.1%) хэрэг Сонгинохайрхан дүүрэгт гарчээ.

Тайлант хугацаанд дүүргийн хэмжээнд гарсан нийт хэргийн 503(40.6%) нь нэгдүгээр хэлтэст, 393(31.7%) нь хоёрдугаар хэлтэст, 344(27.7%) хэрэг нь гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 3. Нийт хэргийн тоо хэлтсээр, хувиар



2018 оны эхний 3 сард нийслэл хотод өмчлөх эрхийн эсрэг 5539 гарсан нь өмнөх оноос 3303 хэргээр буюу 2.5 дахин өссөн байна. Нийслэлд гарсан өмчлөх эрхийн эсрэг хэргийн 1709(30.8%) нь Баянзүрх


дүүрэгт, 1005(18.1%)нь Баянгол дүүрэгт, 914(16.5%) нь Сүхбаатар дүүрэгт, 870 (15.7%) нь Сонгинохайрхан дүүрэгт, 383 (6.9%) нь Хан-уул дүүрэгт, 544 (9.8%) нь Чингэлтэй дүүрэгт, 35 (0.6%) нь Багануур дүүрэгт,75 (1.3%) нь Налайх дүүрэгт, 4 (0.1%) нь Багахангай дүүрэгт гарсан байна.

Хүснэгт 2-ийн үргэлжлэл

Хэрэг бүртгэгдсэн байгууллага	Өмчлөх эрхийн эсрэг		Хулгайлах								Дээрэмдэх	
			Хулгайлах		Хувийн өмч хулгайлах		Автотээврийн хэрэгслэл хулгайлах		Халаасны хулгай			
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Нийслэл	2236	5539	1345	3293	1135	2688	25	109	171	450	92	443
Баянгол	354	1005	163	571	118	440	7	35	38	95	23	107
Баянзүрх	504	1709	317	1058	266	802	8	30	39	205	17	148
Сүхбаатар	445	914	251	505	208	387	1	8	42	101	13	61
Сонгинохайрхан	304	870	200	565	179	512	5	22	10	4	25	82
Хан-уул	192	383	129	208	119	189	2	7	7	7	1	20
Чингэлтэй	395	544	254	310	218	289		4	35	17	13	23
Багануур	15	35	11	19	9	17				1		
Багахангай	3	4	2	3	2	3						
Налайх	24	75	18	54	16	49	2	3				2


Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт гарсан өмчлөх эрхийн эсрэг хэргийн 565(64.9%) нь хулгай, 89 (10.2%) дээрэм, 158 (18.2%) залилангийн хэрэг байна. Дүүргийн хэмжээнд гарсан өмчлөх эрхийн эсрэг хэрэг өмнөх оны мөн үеэс 2,9 дахин өссөн байна.

Зураг 4. Өмчлөх эрхийн эсрэг хэрэг, төрлөөр




Сонгинохайрхан дүүрэгт оны эхний 3 сард гарсан хулгайн хэргийн 247(43.7%) нь нэгдүгээр хэлтэст ,172 (30.4%) нь хоёрдугаар хэлтэст, 146(8.1%) хэрэг нь гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Зураг 5.Хүнд хэргийн тоо хэлтсээр, хувиар



Зураг 6.Хулгайн хэргийн тоо хэлтсээр, хувиар



Оны эхний гурван сард нийслэлд эдийн засгийн гэмт хэрэг 76(0.9%) бүртгэгдснээс 10(13.2%) нь Сонгинохайрхан дүүргийнх байна. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг хэрэг нийслэлд 59 (0.7%) гарснаас 4 (6.8 %) нь Сонгинохайрхан дүүргийнх байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг хэрэг нийслэлд 76 гарснаас 10 (13.1%) нь Сонгинохайрхан дүүрэгт байна.

Хүснэгт 2-ийн үргэлжлэл

Хэрэг бүртгэгдсэн байгууллага	Эдийн засгийн		Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг		олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах		Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг		Авлигын		Нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг		Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Нийслэл	41	76	334	59	274	3	16	31	13	2	55	55	41	76
Баянгол	6	15	62	15	56	1	4	4			7	8	6	15
Баянзүрх	5	13	77	13	67		2	8	4		10	6	5	13
Сүхбаатар	13	19	42	12	35	1	2	7		1	15	13	13	19
Сонгинохайрхан	6	10	66	4	53			4	1		4	7	6	10
Хан-уул	7	9	26	9	20	1	3	6	2		7	3	7	9
Чингэлтэй	4	7	47	6	33		5		6		11	10	4	7
Багануур		2	3								1	5		2
Налайх														

2018 оны эхний 3 сард нийслэл гарсан хэргийн 1262(15.8%) нь даваа гарагт, 1225(15.4%) нь мягмар гарагт, 1144(14.3%) лхагва гарагт, 1177(14.7%) пүрэв гарагт, 1162 (14.6%) баасан гарагт, 1014 (12.7%) бямба гарагт, 961 (12.0%) ням гарагт гарсан байна.

Хүснэгт 3. Гэмт хэргийн тоо, хэрэг гарсан гарагаар, дүүргээр

Гараг	Даваа		Мягмар		Лхагва		Пүрэв		Баасан		Бямба		Ням	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Нийслэл	670	1262	599	1225	623	1174	695	1177	695	1162	567	1014	504	961
Баянгол	134	239	81	212	120	210	101	222	120	224	99	183	91	158
Баянзүрх	125	384	156	343	137	363	181	321	140	327	144	316	110	295
Сүхбаатар	109	177	91	210	124	175	117	197	127	196	99	170	75	144
Сонгинохайрхан	115	188	93	214	83	195	97	179	115	153	81	150	81	161
Хан-уул	49	105	60	94	46	92	80	98	75	105	44	81	54	75
Чингэлтэй	100	137	96	116	93	112	95	121	96	124	83	88	81	89
Багануур	12	9	9	9	7	8	6	17	7	14	9	9	5	18
Багахангай		5	1		1	4	1	2	1	1	2	1		1
Налайх	26	18	12	27	12	15	17	20	14	18	6	16	7	20

Сонгинохайрхан дүүрэгт оны эхний 3 сард гарсан хэргийн 188 (15.2%) нь даваа гарагт, 214 (17.2%) нь мягмар гарагт, 195 (15.7%) лхагва гарагт, 179(14.4%) пүрэв гарагт, 153(12.3%) баасан гарагт,150 (12.1%) бямба гарагт,161 (12.9%) ням гарагт гарсан байна.

Зураг 7. Хэргийн тоо, хэрэг гарсан гарагаар



Даваа гарагт дүүргийн нутаг дэвсгэрт гарсан хэргийн 42.0 хувь нь нэгдүгээр хэлтсийн харъяаны нутаг дэвсгэрт, 26.1 хувь нь хоёрдугаар хэлтсийн харъяалах нутаг дэвсгэрт, 31.9 хувь нь гуравдугаар хэлтсийн харъяалах нутаг дэвсгэрт гарсан байна. Мягмар гарагт дүүргийн хэмжээнд бусад өдрүүдээс их хэрэг гарсан бөгөөд 40.2 хувь нь нэгдүгээр хэлтсийн харъяаны нутаг дэвсгэрт, хоёрдугаар болон

гуравдугаар хэлтсийн харъяалах нутаг дэвсгэрт адилхан 30 орчим хувь нь гарсан байна. Хамгийн бага хэрэг гарсан ням гарагт нийт гарсан хэргийн 34.8 хувь нь нэгдүгээр хэлтэст, 36.6 хувь нь хоёрдугаар хэлтэст, гуравдугаар хэлтэст 28.6 хувь тус тус ногдож байна.

Хүснэгт 4. Гэмт хэргийн тоо, хэлтсээр, гарагаар

Цагдаагийн хэлтэс	Даваа		Мягмар		Лхагва		Пүрэв		Баасан		Бямба		Ням	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
1	61	79	37	86	47	76	44	85	52	62	36	59	29	56
2	22	49	37	64	16	59	24	55	33	52	29	55	26	59
3	32	60	19	64	20	60	29	39	30	39	16	36	26	46

Тайлант хугацаанд нийслэл хотод гарсан хэргийн 2078 (26.1%) нь 06-14 цагт 2468 (30.9%) нь 14-19 цагт, 1172 (14.7%) нь 19-22 цагт, 2257 (28.3%) нь 22-06 цагт гарсан байна. Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт гэмт хэргийн 27.3 хувь нь 06-14 цагт, 29.4 хувь нь 14-19 цагт, 15.6 хувь нь 19-22 цагт, 27.6 хувь нь 22-06 цагт гарчээ. 19-22 цагийн хооронд гэмт хэргийн гаралт бусад цагаас бага байна.

Хүснэгт 5. Гэмт хэргийн тоо, хэрэг гарсан цагаар, дүүргээр

Цаг		Нийслэл	Баянгол	Баянзүрх	Сүхбаатар	Сонгинохайрхан	Хануул	Чингэлтэй	Багануур	Багахангай	Налайх
06-14	2017	994	162	219	178	145	92	172	8		18
	2018	2078	394	555	341	339	146	240	22	5	36
14-19	2017	1305	220	286	236	185	118	212	14	5	29
	2018	2468	392	772	425	365	198	261	22	2	31
19-22	2017	672	106	148	109	117	66	92	9		25
	2018	1172	182	373	181	194	120	89	14		19
22-06	2017	1382	258	340	219	218	132	168	24	1	22
	2018	2257	480	649	322	342	186	197	26	7	48

Зураг 8. Гэмт хэргийн тоо, хэрэг гарсан цагаар




Нийслэл хотод оны эхний 3 сард гарсан хэргийн 2822 (35.4%) нь гэр орон сууцанд , 1417 (17.8%) нь олон нийтийн газарт, 1758(22.0%) нь гудамж талбайд, 149(1.9%) нь нийтийн тээвэрт, 91(1.1%) нь төрийн байгууллагад, 70 (0.9%) нь төрийн бус байгууллагад, 878 (11.0%) нь аж ахуйн нэгжид гарсан байна.

Хүснэгт 6. Гэмт хэргийн тоо, байршилаар, дүүргээр

Хэрэг үйлдэгдсэн газар		Нийслэл	Баянгол	Баянзүрх	Сүхбаатар	Сонгинохайрхан	Хан-уул	Чингэлтэй	Багануур	Багахангай	Налайх
	2018	2822	317	836	364	615	277	315	38	10	50
Олон нийтийн газар	2017	883	209	209	152	81	77	138	7	1	9
	2018	1417	393	431	266	122	65	120	9		11
Гудамж, талбай	2017	947	196	256	128	129	75	139	9		15
	2018	1758	343	634	223	260	107	157	11		23
Нийтийн тээвэр	2017	70	5	7	29	16	6	6		1	
	2018	149	13	21	75	24	11	4			1
Төрийн байгууллага	2017	56	5	9	11	5	6	17			3
	2018	91	7	20	17	11	17	10	3		6
Төрийн бус байгууллага	2017	47	16	10	4	4	2	11			
	2018	70	14	15	14	10	6	6	3	1	1
Аж ахуйн нэгжид	2017	484	93	73	157	61	40	54	1		5
	2018	878	155	203	252	74	73	99	7	3	12
Авто зам	2017	195	27	36	24	50	37	14	4		3
	2018	151	23	45	18	32	18	9			6

Сонгинохайрхан дүүрэгт оны эхний гурван сард гарсан хэргийн 615 (49.6%) нь гэр, орон сууцанд, 122(9.8%) олон нийтийн газарт, 260(20.9%) гудамж талбайд, 24(1.9%) нийтийн тээвэрт, 32(2.6%) хувь нь авто зам дээр, 74(5.9%) аж ахуйн нэгжид, 10(0.8%) ТББ-д, 11(0.9%) төрийн байгууллагад гарсан байна.

Зураг 9. Гэр, орон сууцанд гарсан хэргийн тоо, төрлөөр, Сонгинохайрхан



Тайлант хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэр, орон сууцанд гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 2.2 дахин өссөн бөгөөд гэр орон сууцанд гарсан хэргийн 261(42.4%) гэрт гарсан нь өмнөх оноос 2.5 дахин нэмэгдсэн байна. Орон сууцны байранд 83 (13.5%) хэрэг гарсан нь өмнөх оноос 2.4 дахин, хувийн байшинд 190 (30.9%) хэрэг гарсан нь өмнөх оноос 2.4 дахин өсчээ.


Сонгинохайрхан дүүрэгт оны эхний 3 сард олон нийтийн газарт гарсан өмнөх оны мөн үеэс 50.6 хувиар өссөн бөгөөд гарсан хэргийн хэргийн 17 (13.9%) нь дэлгүүрт, 14 (11.5%) зочид буудалд, 7 (5.7%) бөөний худалдааны төвд, 28 (22.9%) нь бааранд, 22 (18.0%) автовокзалд гарчээ.

Зураг 10. Олон нийтийн газарт гарсан хэргийн тоо, төрлөөр, Сонгинохайрхан



2018 оны эхний 3 сард нийслэл хотод 1215 хүн хэрэг үйлдсэнээс 163(13.4%) нь эмэгтэй байна. Тайлант хугацаанд нийслэл хотод хэрэг үйлдсэн хүмүүсийн 203(16.7%) нь Баянгол дүүргийн, 284(23.4%) нь Баянзүрх дүүргийн, 138(11.4%) нь Сүхбаатар дүүргийн, 256(21.1%) нь Сонгинохайрхан дүүргийн, 84(6.9%) нь Хан-уул дүүргийн, 168(13.2%) нь Чингэлтэй дүүргийн, 57(4.7%) нь Багануур дүүргийн, 20(1.6%) нь Налайх дүүргийн 5 (0.4%) нь Багахангай дүүргийн хүн байна.

Зураг 11. Хэрэг үйлдэгсэд, цагдаагийн хэлтсээр



Хүснэгт 10. Хэрэг үйлдэгсэд, насны бүлгээр, дүүргээр

Үзүүлэлт		Нийслэл	Баянгол	Баянзүрх	Сүхбаатар	Сонгинохайрхан	Хан-уул	Чингэлтэй	Багануур	Багахангай	Налайх	
Бүх хүн	2017	3137	560	662	458	536	328	462	43	5	83	
	2018	1215	203	284	138	256	84	168	57	5	20	
Эмэгтэй	2017	501	90	98	71	64	50	104	10	1	13	
	2018	163	35	23	33	40	5	22	4		1	
Насны бүлэг	15 хүртэлх	2017	33	9	4	2	5	4	6	1		2
		2018	15	2	2	1	8		2			
	16-17	2017	113	12	25	19	22	16	16		1	3
		2018	32	4	9	1	5	1	5	5		1
	18-24	2017	714	160	143	107	124	65	100	4		11
		2018	278	54	65	24	53	26	44	7		5
	25-29	2017	703	117	144	125	107	71	109	10		20
		2018	283	41	58	41	66	19	37	16	1	4
	30-34	2017	528	91	122	71	76	56	87	8	1	16
		2018	226	43	53	27	40	15	33	10	2	3
	35-39	2017	351	51	79	45	72	43	48	7		6
		2018	122	14	34	19	21	10	14	6		4
	40-44	2017	263	45	52	43	52	26	33	1		11
		2018	115	29	25	6	27	7	14	5		2
	45-49	2017	197	37	40	15	40	26	26	3	3	7
		2018	67	4	16	8	24	2	8	4		1
	50-54	2017	130	20	29	16	23	11	22	6		3
		2018	43	8	9	6	9	2	7	1	1	
	55-59	2017	59	10	16	8	8	6	7	1	1	2
		2018	21	2	5	5	3	1	3	2		
60+	2017	41	8	8	6	5	3	7	2		2	
	2018	13	2	8			1	1	1			

Сонгинохайрхан дүүрэгт оны эхний 3 сард 256 хүн хэрэг үйлдсэнээс 40 (15.6%) нь эмэгтэй байна. Дүүргийн хэмжээнд хэрэг үйлдсэн хүнээс 15 хүртэлх настай хүүхэд байхгүй бөгөөд 16-17 настай хэрэг үйлдсэн 5 (1.9%) хүн, 18-24 насны 53 (20.7%) хүн, 25-29 насны 66 (25.8%) хүн, 30-34 насны 40(15.6%) хүн, 35-39 насны 21 (8.2%) хүн 40-44 насны 27 (10.5%) хүн, 45-49 насны 24(9.4%) хүн байна. 50 ба түүнээс дээш насны хэрэг үйлдсэн 12 хүн байна.


Тайлан оны эхний 3 сард нийслэлд хэрэг үйлдсэн хүний 25(2.1%) нь төрийн албан хаагч, 122 (10.0%) нь хувийн хэвшлийн байгууллагын ажиллагчид, 14 (1.1%) нь төрийн бус байгууллагын ажилтан, 227 (18.7%) хувиараа хөдөлмөр эрхлэгч,6 (0.5%) малчин,50 (4.1%) нь оюутан16 (1.3%) сурагч, ажилгүй 754 (62.0%) хүн байна.

Хүснэгт 11. Хэрэг үйлдэгсдийн нийгмийн байдал, дүүргээр

Нийгмийн байдал		Нийслэл	Баянгол	Баянзүрх	Сүхбаатар	Сонгинохайрхан	Хан-уул	Чингэлтэй	Багануур	Багахангай	Налайх
Төрийн албан хаагч	2017	90	18	23	9	11	11	13	1		4
	2018	25	4	8	3	6	2		1		1
Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	2017	283	62	50	40	50	33	38	6		4
	2018	112	26	29	12	10	9	12	10		4
Төрийн бус байгууллагын ажилтан	2017	41	5	6	11	8	7	3			1
	2018	14	3	1	2	4	1	2	1		
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	2017	758	114	175	139	143	63	113			11
	2018	227	47	53	24	44	14	40	2	1	2
Малчин	2017	11	2	3	2		2		2		
	2018	6	0	3		1			2		
Оюутан	2017	141	28	27	34	14	20	18			
	2018	50	15	12	8	2	5	7			1
Сурагч	2017	48	6	12	7	9	2	7	1		4
	2018	16	1	6	1	4	1	1	1	1	
Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл	2017	39	5	8		11	2	5			
	2018	8	1	1	5	4	3	2			
Хоригдол	2017	4	2	1	1						
	2018	3	2						1		
Ажилгүй	2017	1722	318	357	210	290	83	265	33	5	59
	2018	754	104	171	88	181	63	104	39	3	12

Сонгинохайрхан дүүрэгт оны эхний 3 сард хэрэг үйлдсэн хүний 6(2.3 %) нь төрийн албан хаагч, 10(3.9%) нь хувийн хэвшлийн байгууллагын ажиллагчид, 1(2.3%) нь төрийн бус байгууллагын ажилтан, 44(22.7%) хувиараа хөдөлмөр эрхлэгч, 1(0.4%) малчин, 2(0.8%) оюутан, 4(1.6%) сурагч, 4(1.6%) сургууль завсардсан, тэнэмэл хүн, ажилгүй 181(70.7 %) хүн байна. Өнгөрсөн оны мөн үеэс хэрэг үйлдэгчдийн тоо буурсан байна.

Зураг 12. Хэрэг үйлдэгсдийн боловсролын байдал, Сонгинохайрхан



2018 оны эхний 3 сард нийслэл хотод хэрэг үйлдсэн хүмүүсийн 24 (1.9%) нь боловсролгүй, 55(4.5%) нь бага боловсролтой, 196(16.1%) нь суурь боловсролтой, 673(55.4%) нь бүрэн дунд боловсролтой, 45(3.7%) хүн тусгай дунд боловсролтой, 222 (18.23) нь дээд боловсролтой хүн байна. Дүүргийн хэмжээнд хэрэг үйлдсэн хүний 7(2.7%) нь боловсролгүй, 20(7.8%) нь бага боловсролтой, 57(22.2%) нь суурь боловсролтой, 133(51.9%)хүн бүрэн дунд боловсролтой, 9(3.5%) хүн тусгай дунд боловсролтой, 30 (11.7%) нь дээд боловсролтой хүн байна

Хүснэгт 12. Хэрэг үйлдэгсэд боловсролын түвшингээр, дүүргээр

Хэрэг бүртгэгдсэн байгууллага	Боловсролгүй		Бага		Суурь		Бүрэн дунд		Техникийн болон тусгай мэргэжлийн дунд		Дээд	
	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018	2017	2018
Нийслэл	76	24	140	55	489	196	1536	673	124	45	772	222
Баянгол	15	1	21	9	62	21	294	112	35	8	133	52
Баянзүрх	16		26	8	113	40	323	165	24	13	160	58
Сүхбаатар	5	1	21	5	45	19	224	78	23	3	140	32
Сонгинохайрхан	22	7	34	20	115	57	258	133	18	9	89	30
Хан-уул	5	2	12	1	33	15	164	5	9	2	105	13
Чингэлтэй	10	6	15	9	95	31	208	88	12	6	122	28
Багануур	1	6	3	2	8	12	22	27	1	4	8	6
Багахангай				1	1		3	3			1	1
Налайх	2	1	8		17	1	40	16	2		14	2

Зураг 13. Хохирсон иргэн, дүүргээр



Нийслэл хотод 2018 оны эхний гуравдугаар сард гэмт хэргийн улмаас хохирсон 6854 иргэн байгаагаас 3157(46.1%) нь эмэгтэйчүүд байна. Нийслэлд гэмт хэргийн улмаас хохирсон 13 хүртэлх насны хүүхэд

106 (1.5%) байгаагаас Сонгинохайрхан дүүрэгт 18(16.9%) хүүхэд байна. 14-17 насны хохирогч нийслэлд 188(2.7%) байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт 27(14.4%) байна. Нийслэлд 50-54 насны хохирогч 420(6.2%) байгаагийн 93(22.1%) нь Сонгинохайрхан дүүрэгт байна.

Тайлант хугацаанд гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 1169(17.1%) Баянгол дүүргийн, 2152(31.4%) Баянзүрх дүүргийн, 983(14.3%) Сүхбаатар дүүргийн, 1194(17.4%) Сонгинохайрхан дүүргийн, 442(6.4%) Хан-уул дүүргийн, 710(10.3%) Чингэлтэй дүүргийн, 87(1.3%) Багануур дүүргийн, 122(1.8%) Налайх дүүргийн, 5(0.1%) Багахангай дүүргийн иргэд байна.

Хүснэгт 13. Гэмт хэргийн хохирогчид, насны бүлгээр, дүүргээр

Үзүүлэлт		Нийслэл	Баянгол	Баянзүрх	Сүхбаатар	Сонгинохайрхан	Хан-уул	Чингэлтэй	Багануур	Багахангай	Налайх
Нийт хохирсон иргэн	2017	4252	737	980	661	673	391	636	59	22	93
	2018	6854	1169	2152	983	1194	442	710	87	5	112
эмэгтэй	2017	1835	312	430	283	272	173	293	31	13	28
	2018	3157	544	998	461	534	200	334	36	2	48
13 хүртэл настай	2017	69	9	17	11	13	8	8	1		2
	2018	106	20	30	13	18	11	9	2		3
14-17	2017	109	21	23	13	22	9	19			2
	2018	188	33	70	29	27	10	12	1	1	5
18-24	2017	641	120	151	132	79	43	98	7	3	8
	2018	961	200	330	155	128	40	89	9		10
25-29	2017	820	156	193	141	117	75	108	10	4	16
	2018	1315	251	399	206	216	74	131	19	1	18
30-34	2017	748	147	153	105	114	70	126	7	8	18
	2018	1164	197	375	157	203	77	121	9		25
35-39	2017	497	81	122	64	82	46	83	7		12
	2018	866	143	255	110	173	75	91	8	1	10
40-44	2017	446	70	104	52	79	44	70	12	4	11
	2018	693	111	208	109	124	44	73	12		12
45-49	2017	344	62	77	51	55	35	46	6		12
	2018	576	79	185	74	106	39	72	10		11
50-54	2017	257	32	73	40	53	20	30	2	2	5
	2018	420	56	126	59	93	24	50	6		6
55-59	2017	151	15	33	26	28	19	26	3	3	1
	2018	253	36	85	28	46	17	28	6		7
60+	2017	170	24	34	26	31	22	22	4		6
	2018	313	43	89	43	54	31	34	4		4

Тайлант хугацаанд нийслэлд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын 253(3.7%) нь 55-59 насны иргэд байгаагаас 46(18.2%) нь Сонгинохайрхан дүүргийн иргэд байна. 60-аас дээш настай хохирогч нийслэлд 246(3.6%) байгаагаас 54(21.9%) Сонгинохайрхан дүүргийнх байна.

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах тоглоом 

Валютын ханш 



©2017


аппликейшнаас


СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab | Тооллого судалгааны микро мэдээллийн сан




Social network

 www.facebook.com/StatisticMongolia/


 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn